

АГУУЛГА

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН АНХДУГААР ЧУУЛГАНЫ ТУХАЙ	3
НЭЭЛТИЙН ҮГ.....	4
МЭНДЧИЛГЭЭ.....	6
ЧУУЛГАНЫ ҮЕЭР ТАНИЛЦУУЛСАН ИЛТГЭЛҮҮД:	7
БҮС НУТГААР ХУВААГДАН ОРОЛЦСОН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН:.....	9
БАРУУН БҮС:.....	10
ТӨВИЙН БҮС.....	12
ГОВИЙН БҮС.....	14
ЗҮҮН БҮС.....	16
ХАНГАЙН БҮС-1.....	18
ХАНГАЙН БҮС-2.....	20
ХУРААНГУЙ	22
АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТУХАЙ.....	23
АӨЧТ-гийн ИНФОГРАФИК.....	32

ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АӨЧТ	Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
МАА	Мал аж ахуй
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
ОХУ	Оросын Холбооны Улс
УИХ	Улсын Их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН АНХДУГААР ЧУУЛГАНЫ ТУХАЙ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ) нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу хэмжиж, энэ чиглэлээр өргөн цар хүрээтэй мэдээллийн сан бүрдүүлэхийг зорин ажилладаг. Бид судлаач, бодлого боловсруулагчид төдийгүй олон нийтийн

хувьд найдвартай эх үүсвэр болгон ашиглагдахуйц судалгаа хийхийг гол чиглэлээ болгон судалгаа шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв өгөгдөл, аргачлалыг ашиглахыг ямагт эрмэлздэг. Түүнчлэн аливаа судалгаа, үйл ажиллагаа нь улс төрийн болон хувийн ашиг сонирхлоос үл хамааралтай байх нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг билээ.

Судалгааны үр дүнд Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулах хамгийн дөт бөгөөд үр дүнтэй арга замыг тодорхойлж, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах нь бидний эрхэм зорилго билээ.

ЭЗБӨЧСТ нь Швейцарьт төвтэй Дэлхийн өрсөлдөх чадварын төвтэй хамтран “Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан” иж бүрэн судалгааг тав дахь жилдээ боловсруулан гаргахаар ажиллаж байна. Үүний зэрэгцээ бид энэхүү судалгааны арга зүйд тулгуурлан 2013 оноос эхлэн Монгол Улсын 21 аймгийн өрсөлдөх чадварыг харьцуулан судалсан “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан” (АӨЧТ)-г хоёр дахь жилдээ хийсэн билээ.

буй эсвэл дээшлүүлж буй үзүүлэлтүүдийг тодорхойлж, өрсөлдөх чадварын давуу болон сул талыг үнэлэх боломж олгож буй нь энэхүү судалгааны давуу тал юм.

АӨЧТ-гийн гол зорилго нь Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн өнөөгийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгуудын өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлоход оршино. Аймаг тус бүрийн өрсөлдөх чадварыг хойш татаж

Төвийн зүгээс ХБНГУ-ын Конрад Аденауэрын сантай хамтран АӨЧТ-гийн үр дүнг хэрхэн ашиглах, аймгуудын өрсөлдөх чадварыг цаашид хэрхэн сайжруулах талаар хэлэлцэхээр “Аймгуудын өрсөлдөх чадварын анхдугаар чуулган”-ыг 2014 оны 10 дугаар сарын 8-9 нд зохион байгуулав. Чуулганд 21 аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, болон МҮХАҮТ-ын орон нутаг дахь салбар танхимуудын дарга нар зэрэг орон нутгийн шийдвэр гаргагчдын 60 гаруй төлөөлөл оролцож санал бодлоо солилцов.

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ЧУУЛГАНЫ ЗОРИЛГО



АӨЧТ-г хэрхэн бэлтгэдэг талаар мэдээлэл, ойлголтыг түгээх. Өрсөлдөх чадвар гэж юу болох түүнийг судлахын ач холбогдлыг таниулах.



Бүс нутгийн давуу болон сул талыг тодорхойлж, бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох.



АӨЧТ-д ашигладаг статистик мэдээллийг хэрхэн боловсруулдаг талаар мэдээлэл олгох.



Бүс нутгийн эдийн засгийн тулгуур салбарыг тодорхойлж, түүнийг хөгжүүлэхийн тулд цаашид хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлох.



Бүсчилсэн хэлбэрээр хөгжихийн давуу талыг тодорхойлох.

НЭЭЛТИЙН ҮГ

ЭЗБӨЧСТ-ийн Удирдах зөвлөлийн дарга П.Цагааны хэлсэн үг



Аймгуудын өрсөлдөх чадварын анхдугаар чуулган нь түүхэнд тэмдэглэгдэх арга хэмжээ болж байна. Энэхүү чуулганыг ЭЗБӨЧСТ-ийн зүгээс Монгол Улс ардчиллын замыг сонгосон цагаас хойш дотно хамтын ажиллагаатай явж ирсэн Конрад Аденауэрийн сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж байгаа нь сайшаалтай.

“Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан”-г анх гаргахдаа Монголтой эдийн засгийн бүтэц, хүн ам, шилжилт зэрэг ямар нэг байдлаараа ижил төстэй дэлхийн янз бүрийн тивийн 14 оронтой 330 гаруй үзүүлэлтээр харьцуулан гаргасан. Эдгээр үзүүлэлтүүд нь дэд бүтэц, эдийн засаг, нийгмийн, засаглалын зэрэг олон талыг хамардаг. Энэхүү судалгаагаар Монгол Улс өрсөлдөх чадвараараа дэлхийд хаана байгааг тодорхойлохыг зорьсон. ЭЗБӨЧСТ-өөс 2013 онд анх удаа 21 аймгийг 180 гаруй үзүүлэлтээр харьцуулан судалсан АӨЧТ-г гаргасан. Энэхүү тайланг жил бүр тогтмол гаргадаг болсноор “аймгуудыг” өнгөрсөн нэг жилд ямар үзүүлэлтээр урагшлав, ямар үзүүлэлтээр ухрав гэдгийг тодорхойлох боломжтой болсон билээ.

Та нар бол аймаг, орон нутгийг удирдаж байгаа хүмүүс. Та бүхэнд хамгийн эхэнд зөвлөх зүйл бол бүртгэл. Тэгээд хэмжүүр. “Аливаа юмыг хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй. Хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй” гэсэн Ромоос гаралтай

эртний зүйр үг байдаг. Аливаа зүйлийг удирдаж чадахгүй бол боловсронгуй болгож чадахгүй. Улс орон, аймаг, орон нутгийг удирдахын тулд хамгийн түрүүнд бодит хэмжүүртэй болох хэрэгтэй. Хэмжүүр гэдэг ганц үг маш гүнзгий утга учиртай. Байгалийн шинжлэх ухаанаас гадна эдийн засаг, нийгмийн шинжлэх ухаан хөгжсөөр байгаа өнөө үед хэмжиж болохгүй зүйл гэж үгүй болсон. Хамгийн эхлээд хэмжиж сурах нь зүйтэй. Аймгууд эхлээд өөрсдийгөө бодит шалгуураар хэмждэг болно гэдэг бол улс орон, аймаг, орон нутгийг удирдах үндсийн үндэс, толь нь болж байгаа юм. Гэхдээ нөлөөтэй биш, бодитой толь юм. Хөгжлийн гайхамшигийг бүтээхэд өрсөлдөх чадвар чухал. Үүнд та бүхний үүрэг асар их юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч өнгөрсөн оны 11 дүгээр сард “Том төрөөс ухаалаг төр рүү” гэсэн санаачилга дэвшүүлж томоохон хурал зохион байгуулсан. Ухаалаг төр рүү шилжих зайлшгүй шаардлагатай гэсэн бүх тооцоо судалгаа, үндэслэлүүд нь таван жилийн хугацаанд хийсэн Монгол Улсын өрсөлдөх чадварын судалгаа байсан юм. Иймээс судалж, хэмжиж чадна гэдэг бол тал бүрийн ач холбогдолтой юм. Өрсөлдөх чадвар судлалыг нарийн шинжлэх ухаан гэж ойлгох хэрэгтэй. Өмнөговь аймаг хүсэлт гаргаад “Сумдын өрсөлдөх чадварын тайлан”-г манай төвөөр гаргуулаад байна. Монгол Улсын жил болгоны эдийн засгийн форум дээр “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан”-гийн үр дүнг хэлэлцдэг хэвшил тогтоод явж байгаа. Энэ тайланг Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар, та бүхэн ашигладаг болж байгаа нь чухал юм.

Өнгөрсөн жилээс Ерөнхийлөгчийн санаа-чилгаар Монгол Улсад анх удаа хөрөнгө оруулалтыг орон нутагт нь шилжүүлж, төсөв, орон нутгийн хөгжлийн

санг иргэдийн шууд оролцоотойгоор, тэдний саналаар хуваарилж эхэллээ. Үүнийг иргэд маш их сайшаан хүлээж авч байгаа. Би яагаад шууд ардчилал-иргэдийн оролцооны талаар ярьсан бэ гэвэл Монгол Улс өнгөрсөн 24 жилд сонгуулийн ардчилалтай байсан. Одоо ирэх 24 жилд иргэдээсээ санал асууж, тэднээр шийдвэр гаргуулдаг шууд ардчилал руу оръё гэж байгаа. 2009 онд анх Иргэний танхимыг Төрийн ордонд байгуулж байсан бол өнөөдөр аймаг, сум, нийслэл, дүүрэгт 300 гаруй Иргэний танхим байгуулагдаад байна. Иргэдээр шийдвэр гаргуулдаг болох юм бол Монгол Улс хүчтэй, жигд хөгжсөн улс болох боломжтой.

Үүний зэрэгцээ төр төвхнүүлэх үйл ажиллагаа булингартай байгаа. “Усны эх нь булингартай бол адаг нь булингартай” гэсэн зүйр үг байдаг. УИХ, Иргэдийн Хурал, Засаг даргын гээд аль ч шатны сонгууль булингаргүй, тунгалаг явах юм бол уг байгууллага, уг хүний үйл ажиллагаа бас булингаргүй, тунгалаг байна. Үүнтэй холбогдуулж хэлэхэд Сонгуулийн хууль, санхүүжилтийн хууль, нэр дэвших хуулийг боловсронгуй болгож 2016 онд үнэхээр булингаргүй төр, засгийг төвдөө ч, орон нутагтаа ч байгуулъя гэсэн бодлоготой байна.

Үүний зэрэгцээ хоёр зарчим барья гэж байгаа. Нэгд, тухайн сонгуулийн байгууллага, албан тушаалд өрсөлдүүлэх зарчим нь тэгш оролцоог дэмжсэн байх ёстой. Энэ юу гэсэн үг вэ гэвэл эрүүл саруул, эрдэм боловсролтой, тухайн ажлыг хийж чадах ямар ч хүн өрсөлдөх боломжтой байх ёстой. Өнөөдөр мөнгөний үүрэг роль их байгаа учраас сонгуулиар байгуулагддаг байгууллагууд мөнгөтэй, бизнесийн хүмүүсийн клуб болчих гээд байгаа тал бий. Иймээс төр, засгийн байгууллагад

сонгогдож ажиллах хүмүүс мөнгөний шалгуураар биш, олон хүн өрсөлддөг хуулийн зохицуулалтаар гарч ирэх ёстой. Хоёрдугаарт, тэгш өрсөлдөх боломжтой байх ёстой. Энэ хоёр зарчмаар хатуу чанд хууль боловсруулж байгаа гэдгийг хэлье.

Шилэн дансны тухай хууль гэж та бүхэн сонссон. Энэ хууль ирэх жилээс мөрдөгдөж эхэлнэ. Энэ хуулийн дагуу 2015 оны 1-р сарын 1-нээс таван сая төгрөгөөс дээш бүх орлого, зарлагын гүйлгээ байгууллагынхаа веб хуудсан дээр тавигдана. Веб хуудасгүй бол самбар дээр, олон нийтийн нүдэн дээр ил тод тавина. Тэгж тавиагүй бол нэг, хоёрдугаар гарын үсэг зурдаг хүмүүс ажлаасаа чөлөөлөгдөх үндэслэл болно. Сонгуульд оролцож байгаа нам, бүх хүмүүс сонгуульд зарцуулах мөнгөө мөн Шилэн данстай адилхан нэг дансанд төвлөрүүлж захиран зарцуулдаг болно. Шилэн дансны тухай хууль бол төр, засгийн үйл ажиллагааг булингаргүй байлгах их том утгаар гарсан хууль шүү. Энэ хууль төрийн байгууллагаас эхлээд дараагаар нь төрийн өмчийн оролцоотой аж ахуйн бүх нэгжүүдэд хамаарна. Дараа нь улс төрийн намуудад хамаарна.

Би та бүхэнд гурван зүйл хэллээ. Нэгд, ухаалаг төр гэдэг бол урт процесс. Үүн дотор сонгуулийн хууль, санхүүжилтийн хууль, нэр дэвших хууль, тайлагнах, өрсөлдөх чадвар гээд их олон зүйл багтана. Хоёрт, шууд ардчилал, орон нутгийн оролцоо гэдэг бол түр зуурын ажил биш. Монголын иргэд хүчтэй байвал хүчтэй улс болно. Гуравт, Шилэн дансны хуулиар төр, засгийн бүх үйл ажиллагаа ил тод болоод ирвэл олон нийтийн шууд хяналтад орно. Төсвийн хөрөнгийг юунд захиран зарцуулж байна вэ гэдэг нь ил болно. Хяналттай болно” гэлээ.

МЭНДЧИЛГЭЭ



Конрад Аденауэрын сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Иоханнес Д.Рай

Юуны өмнө өнөөдрийн үйл ажиллагааг хүндэтгэн, хүрэлцэн ирсэн та бүхэнд талархал илэрхийлье. Анх Монголд ирснээс хойш 4 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд Монгол Улсын 21 аймагт олон удаа очиж байсан. Мөн Герман хэлээр маш сайн ярьдаг олон хүмүүстэй таарч байлаа. Монголчуудын хэл сурах авьяас гайхалтай сайн санагдсан.

Монгол улсад одоогоор Германы гурван том улс төрийн сан үйл ажиллагаагаа явуулж байна. Манай сан Монгол Улсын

Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран орон нутгийн өөрөө удирдах тогтолцоо, төвлөрлийг сааруулах тал дээр олон үйл ажиллагаа явуулдаг. Тиймээс та бүхэн манай сангийн талаар сайн мэдэх байх.

Манай сангийн урилгаар өнөөдрийн хэлэлцүүлэгт оролцож, санал бодлоо солилцож өрсөлдөх чадварын талаар илтгэл тавихаар Проф.Др. Ханс-Римберт Хеммер хүрэлцэн ирсэн байгаа. Тэрээр 8 дахь удаагаа Монголд ирж байгаа бөгөөд манай сангийн шугамаар 4 дэх удаагаа ирж байна. Тэрээр 80 гаруй оронд макро эдийн засгийн зөвлөгөө өгч байсан ба энэ чиглэлээр ажилладаг эрдэмтэн, судлаач юм. Ажлын болоод амьдралын маш их туршлагатай ба зөвхөн онолын талаас маш сайн мэдлэгтэй төдийгүй практик дээр ч мөн маш сайн хэрэгжүүлдэг. Түүнээс сурах зүйл маш их байх болно. Тэрээр их чөлөөтэй сэтгэдэг ба зарим зүйлд их хүчтэй шүүмжлэлтэй хандаж чаддаг. Та бүхний ажилд ч мөн шүүмжлэлтэй хандаж магадгүй тул түүний зөвлөмжийг хүлээн авахад бэлтгэлтэй байхыг хүсье.

МҮХАҮТ-ын орлогч дарга М.Оюунчимэг

Эдийн засгийн хөгжлийг хэмжихэд судалгаа шинжилгээ зайлшгүй шаардлагатай. Орон нутаг дахь МҮХАҮТ-ын салбар нэгжүүд хөндлөнгийн ямар нэг хүчин зүйлийн нөлөөгүйгээр аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны санал асуулгыг авч явуулдаг. Энэхүү судалгаа нь засаглал, бизнесийн орчин, хариуцлагатай бизнес, ил тод байдал зэрэг манай улсын зайлшгүй шийдвэрлэх асуудлуудыг агуулдаг сайн судалгаа юм.



ЧУУЛГАНЫ ҮЕЭР ТАНИЛЦУУЛСАН ИЛТГЭЛҮҮД:

ЭЗБӨЧСТ-ийн Ерөнхий захирал Б.Лакшми



МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ:

- Монгол Улсын эдийн засагт үүсээд буй асуудлууд
- Эдийн засгийн цаашдын хандлага

Гийсэн хотын их сургуулийн Эдийн засаг, хөгжиж буй орнууд судлалын профессор, GOPA (Worldwide Consultants) консалтинг компанийн судалгааны төвийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний ахлах зөвлөх

Проф.Др. Ханс-Римберт Хеммер



БҮС НУТГИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР:

- Өрсөлдөх чадвар гэж юу вэ?, Бүс нутгийн өрсөлдөх чадвар
- Өрсөлдөх чадварын зорилгоо тодорхойлох, өрсөлдөх чадварыг хэмжих

ЭЗБӨЧСТ-ийн Судалгааны мэргэжилтэн Э.Тунгалаг



АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР; ХӨГЖЛИЙН ДУУДЛАГА.

- Өрсөлдөх чадвар гэж юу вэ?, Монгол Улсын өрсөлдөх чадвар
- Аймгуудын өрсөлдөх чадварын судал-гааны тухай, гол үр дүн
- Аймгуудын өрсөлдөх чадварын давуу, сул талууд

Л.Эрхэмбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх



ХОТ ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, Хот тосгоны эрх зүйн үндэс
- Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Хууль батлагдсаны үр дагавар, ач холбогдол

М.Оюунчимэг, МҮХАҮТ-ын орлогч дарга



ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР МҮХАҮТ-ААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖЛУУД:

- Орон нутагт чиглэсэн МҮХАҮТ-ын үйл ажиллагаа, төслүүд
- Орон нутагт жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих арга зам

Б. Саранчимэг, ҮСХ-ны хүн ам нийгмийн статистикийн газрын орлогч дарга



АЛБАН ЁСНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ, ТЭДГЭЭРИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ:

- Статистикийн мэдээлэл гэж юу вэ?
- Мэдээллийн эх үүсвэр

А.Дэмбэрэл, ҮСХ-ны мэдээлэл сургалт, сурталчилгааны төвийн дарга, Эдийн засгийн ухааны доктор, профессор



ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ТООЦОХ АРГА ЗҮЙ:

- Эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүдийг тооцож буй арга зүй
- Статистик мэдээллийг хаанаас авах вэ?

БҮС НУТГААР ХУВААГДАН ОРОЛЦСОН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН:

Хоёр өдрийн арга хэмжээний үеэр оролцогчид бүс нутгаар хуваагдан, баг болон оролцсон. Эхний өдөр өөрийн бүс нутгийн хөгжлийн давуу болон сул талыг тодорхойлсон бөгөөд бүс нутгийн хэмжээнд нэн түрүүнд шийдвэрлэх ёстой таван бэрхшээлийг эрэмбэлэн, түүнийг шийдвэрлэснээр гарч болох үр дүнг тодорхойлсон. Харин хоёр дахь өдөр багууд бүс нутгийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур салбаруудыг тодорхойлсон.



БАРУУН БҮС:

Давуу тал буюу БОЛОМЖ

- Нутгийн цэвэр угшлын эрүүл мал сүрэг
- Ажиллах хүчний нөөц (иргэд нь ажилсаг)
- Гадаад харилцаа, худалдааг хөгжүүлэх газарзүйн боломж (ОХУ, БНХАУ, Казахстан)
- Иргэдийн боловсролын түвшин өндөр
- Газар нутгийн унаган төрхөө алдаагүй, байгалийн баялаг ихтэй.



Сул тал буюу АСУУДАЛ

- Дэд бүтцийн хөгжил сул (зам, цахилгаан, дулаан)
- Үйлдвэр хөгжөөгүй (уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл)
- Бүс нутгийг дэмжсэн бүсчилсэн болон төсөв санхүүгийн бодлогын хэрэгжилт хангалтгүй.
- Шатахуун болон суурь бүтээгдэхүүний үнэ өндөр
- Газар тариаланг ихээр хөгжүүлэх боломжгүй (усжуулалт муу) эрдэм шинжилгээ, судалгааны ажил хангалтгүй

Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 Дэд бүтцийн хөгжил сул (зам, цахилгаан, дулаан)	– Төвөөс алслагдсан байдал. – Дэд бүтцийг хөгжүүлэхэд өртөг өндөр.	– Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх. – ГШХО-ыг нэмэгдүүлэх бүсийн нэгдсэн бодлоготой болох.	– Бараа бүтээгдэхүүний үнэ буурч, амьжиргааны түвшин дээшилнэ.
2 Үйлдвэрлэл хөгжөөгүй (уул уурхай, боловсруулах)	– Бүс нутгийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт хангалтгүй. – Зах зээлийн багтаамж муу.	– Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг сайжруулах. – Үйлдвэрлэлийг дэмжсэн эрх зүйн болон хөрөнгө оруулалтын орчин бий болгох.	– Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэж ажилгүйдэл буурна.
3 Бүс нутгийг дэмжсэн төсөв санхүүгийн бодлогогүй.	– Бүс нутгийн хөгжлийг дэмжсэн бодлогыг удирдах бүтэц засгийн газарт байдаггүй, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, бодлогогүй.	– Бүс нутгийн хөгжлийг дэмжсэн хууль гаргах.	– Тогтвортой хөгжлийн суурь үзүүлэлт сайжирна.
4 Шатахуун болон суурь бүтээгдэхүүний үнэ өндөр.	– Тээврийн зардал өндөр. – Төрийн зохицуулалтгүй.	– Монгол Улсын хэмжээнд нэг үнийн системд шилжих. – Бүсийн татварын хөнгөлөлт бий болгох.	– Суурь бүтээгдэхүүний үнэ тогтворжиж ард иргэдийн орлого нэмэгдэнэ.
5 Газар тариаланг их хэмжээгээр хөгжүүлэх боломжгүй. (усжуулалт муу)	– Үржил шимт хөрстэй газар бага. – Гадаргын усны нөөц бага – Цаг уурын эрс тэс уур амьсгалтай	– Байгаль цаг уурт тохирсон технологи, сорт, үр бий болгох. – Усжуулалтыг сайжруулах	– Бүс нутгийн хэрэгцээг хангана – Үйлдвэрлэлийг нэмэгдүүлж ажлын байрыг бий болгоно.

Баруун бүсийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:



- Транзит тээвэр-Ложистикийн төв
- Аялал жуулчлал
- Уул уурхай
- МAA-н боловсруулах үйлдвэр (мах, түүхий эд)
- Эрчим хүчний үйлдвэрлэл (сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй хосолсон)
- Шинжлэх ухааны болон үйлдвэр технологийн парк
- Байршлын давуу тал (гадаад худалдаа)
- Чөлөөт бүс
- Тэжээл үйлдвэрлэл

Баруун бүсийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур САЛБАР:

МАЛЫН ТҮҮХИЙ ЭД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

Өнөөгийн нөхцөл байдал:

- Баруун бүсэд 12 сая толгой мал байна.
- Одоогоор малын түүхий эд боловсруулах үйлдвэр байхгүй байна.
- Эдийн засгийн үр ашиг бага байна.

Цаашид түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:

- Үйлдвэр технологийн парк, кластер байгуулах.
- Бүсийн хэмжээний төлөвлөлт хийж нөөцийг тогтооно.
- Үйлдвэрийн дэд бүтцийг байгуулах (агуулах, цахилгаан дулаан, ус).
- Түүхий эд цуглуулах сүлжээ байгуулах.

Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:

- Баруун бүсийн нэмүү өртөг өснө.
- Шинээр ажлын байрууд бий болно.
- Амьжиргаа дээшилнэ.
- Орон нутагт төсвийн орлогын эх үүсвэр бий болно.
- Хүнсний аюулгүй байдлын баталгаа хангагдана.
- Дагуул бичил бизнесүүд бий болно.

ТӨВИЙН БҮС

Давуу тал буюу БОЛОМЖ

- Газарзүйн байршил. (дэд бүтэц, зам харилцааны хөгжил сайн)
- Газар тариалан, ХАА-н үйлдвэрлэл хосолж, өрхийн үйлдвэрлэл илүү хөгжсөн.
- Мэргэжлийн ажиллах хүч, хүний нөөцийн чадавхи өндөр.
- Байгалийн нөөц баялаг их, газар нь эдийн засгийн эргэлтэнд бүрэн орсон, хот төлөвлөлт сайн.
- Гадаад худалдаа, хил гаалийн өргөн боломжтой, эдийн засгийн чөлөөт бүстэй.



Сул тал буюу АСУУДАЛ

- Байгаль орчны тэнцвэрт байдал алдагдсан.
- Хүн амын шилжилт хөдөлгөөн, нягтралаас болж гэмт хэргийн гаралт их.
- Олон Улсын авто зам, төмөр замын сүлжээ болон нийслэлтэй ойр зэргээс шалтгаалан үйлдвэрлэл, үйлчилгээний зах зээлээ алдах боломж их.
- Хил залгаа аймаг болон сумд хоорондын хилийн маргаан их.
- Малчин, тариаланчдын хоорондын газрын зөрчил их

Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 Байгаль орчны тэнцвэрт байдал алдагдсан: – Модны хулгай, ой, хээрийн түймэр – Агаарын бохирдол – Хог хаягдал	– Уул уурхайн компаниуд нөхөн сэргээлт хийдэггүй, түүнд тавих төр, иргэний хяналт муу, үйлдвэрлэлийн технологийн хоцрогдол.	– Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх – Хяналтыг сайжруулах – Иргэний хариуцлагыг нэмэгдүүлэх.	– Байгаль орчин нөхөн сэргэж, иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.
2 Хүн амын шилжилт хөдөлгөөн суурьшлын нягтралаас болж гэмт хэргийн гаралт их.	– Зам тээвэр суурьшлын гол зангилаа учраас.	– Хяналтаа сайжруулахад зориулж хөрөнгө гаргаж, хяналтыг сайжруулж, урьдчилан сэргийлэх.	– Гэмт хэргийн гаралт буурч, хяналтын тогтолцоо сайжирна.
3 Олон Улсын авто зам болон төмөр замын сүлжээ дайран өнгөрдөг, мөн нийслэлтэй ойр учраас үйлдвэрлэл, үйлчилгээний зах зээлээ алдах боломж их.	– Газарзүйн байршил.	– Үйлдвэрлэлийг шинээр бий болгоход санхүүжилтыг нэмэгдүүлэх. – Гадны бүтээгдэхүүн оруулахад хязгаар тавих.	– Бүс нутгийн хэмжээнд өөрийн гэсэн брендтэй болно. – Бүс нутгийн иргэд, бизнес эрхлэгчдийн орлого сайжирна.
4 Хилийн цэсийн маргаантай байдал – Аймаг хооронд – Аймаг дотроо сум хооронд	– Хилийн цэсийн шугам тодорхой бус. – Газар нутгийн дахин хуваарилалт. – Хот төлөвлөлт.	– УИХ-ын түвшинд асуудлыг даруй шийдвэрлэх (Хугацаа их алдаж байна).	– Шинэ төлөвлөлт хийхэд нөлөөлнө. – Газар эдийн засгийн эргэлтэнд орох боломжтой.
5 Малчин тариаланчдын хоорондын зөрчил их	– Газар тариалангийн талбай болон малын бэлчээрийн давхцал. – Малчдын шилжилт хөдөлгөөн их.	– Хариуцлагаа ухамсарлах. – Газар тариалангийн талбайгаа хашаажуулах. – Эрчимжсэн МАА-г төрөөс дэмжих. – ХАА-н шинэ технологи нэвтүүлэх.	– Малчид, тариаланчдын хоорондын маргаан багасна. – Сүү, махны гарц, үр ашиг сайжирч, тогтвортой ажлын байр бий болно.

Төвийн бүсийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:



- Хүнд үйлдвэр (Төмөрлөг, металлурги)
- Барилгын материал
- Хүнсний бүтээгдэхүүн (мах, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүн)
- Хөнгөн үйлдвэр, арьс шир, оёмол, сүлжмэл
- Тээвэр, ложистик
- Аялал жуулчлал-гадаад, дотоод
- Газар тариалан
- Эрчимжсэн мал аж ахуй
- Уул уурхай
- Гадаад дотоод худалдаа
- Аж үйлдвэр (технологийн парк)

**Төвийн бүсийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур САЛБАР:
ҮЙЛДВЭРЛЭЛ-БУХ ТӨРЛИЙН ХҮНД, ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ**

Өнөөгийн нөхцөл байдал:

- Төмөрлөг, жонш, МАА-н бүтээгдэхүүн, ноос, сүү, өндөг, нүүрс, цемент, барилгын материал, хүнс гэх мэт үйлдвэрлэлийн салбар хөгжсөн.
- Үйлдвэрлэлийг дэмжих тээвэр, ложистик хөгжсөн.
- Зах зээлийн багтаамж их.

Цаашид түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:

- Дэвшилт технологийг нэвтрүүлэх.
- Мэргэжлийн боловсон хүчнээр хангах.
- Бизнесийн эрх зүйн орчинг сайжруулах (таатай орчин бүрдүүлэх).
- Бүсийн аймгууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах.

Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:

- Бүс нутгийн брендүүд, кластер бий болно.
- Хувийн хэвшлийнхний өрсөлдөх чадвар сайжирна.
- Монгол Улсын экспортыг нэмэгдүүлнэ.
- Импортыг орлох бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.
- Ажилгүйдэл, ядуурал буурна.
- Ажлын байр нэмэгдэнэ.

ГОВИЙН БҮС

Давуу тал буюу БОЛОМЖ

- Уул уурхай
- Байршил, (Баруун аймгуудтай холбогдох замын сүлжээ)
- Дэд бүтэц (Аж үйлдвэрийн парк, цахилгаан станц, нарны эрчим хүчний станц барих боломжтой)
- Аялал жуулчлал (Дэлхийн энергийн төв зэрэг жуулчдыг татах олон газруудтай мөн нийслэлтэй засмал замаар холбогдсон).
- Говийн амттай мах



Сул тал буюу АСУУДАЛ

- Цөлжилт
- Байгаль орчны бохирдол.
- Хүн ам сийрэг.
- Орлогын тэгш бус байдал.
- Боловсон хүчин хомс.

Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 Цөлжилт	<ul style="list-style-type: none"> - Хуурайшилт - Тоосжилт - Усны хомсдол - Хариуцлагагүй уул уурхай 	<ul style="list-style-type: none"> - Орхон (Хэрлэн) голоос говийн бүс рүү гольдрол үүсгэж шинэ нуур, цөөрмүүд байгуулах. 	<ul style="list-style-type: none"> - Цөлжилтийг багасгана. - Байгаль орчныг сэргээнэ. - Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжинэ.
2 Байгаль орчны бохирдол	<ul style="list-style-type: none"> - Хүний буруутай үйл ажиллагаа. - Хариуцлагагүй уул уурхай 	<ul style="list-style-type: none"> - Уул уурхайг дэс дараалалтай ашиглах - Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх - Нөхөн сэргээх - Мод тарих 	<ul style="list-style-type: none"> - Хүн амьдрахад таатай орчин бүрдэнэ. - Экологийн тэнцвэрт байдал хадгалагдана.
3 Хүн ам сийрэг	<ul style="list-style-type: none"> - Төрөлт багассан - Шилжих хөдөлгөөн 	<ul style="list-style-type: none"> - Нутгийн хишиг олгох. - Говийн нэмэгдэл олгох - Хүн амын өсөлтийг дэмжих. - Бүс нутгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Хүн амын тоо өснө. - Ажиллах хүч нэмэгдэж, үйлдвэрлэл хөгжинө.
4 Орлогын тэгш бус байдал	<ul style="list-style-type: none"> - Хууль, эрх зүй - Монополь орчин 	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг бий болгох. - Хууль эрх зүйн орчинг сайжруулах. 	<ul style="list-style-type: none"> - Иргэдийн амьжиргаанд эерэг нөлөөлнө.
5 Боловсон хүчний хомсдол	<ul style="list-style-type: none"> - Их дээд сургууль байхгүй. - Шилжих хөдөлгөөн их. 	<ul style="list-style-type: none"> - Бүс нутгийн тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. - Их дээд сургууль байгуулах. - Залуу боловсон хүчнийг ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн ажиллах хүчин нэмэгдэнэ.

Говийн бүсийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:



- Уул уурхай-Боловсруулах үйлдвэр
- Аялал жуулчлал-Соёлын урлал
- Тээвэр агуулахын аж ахуй
- Барилгын материалын үйлдвэрлэл
- Эрчим хүч, дулаан хангамж
- МAA-Тэмээний аж ахуй

Говийн бүсийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур САЛБАР:

УУЛ УУРХАЙ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

Өнөөгийн нөхцөл байдал:

- Хууль эрх зүйн орчин тогтворгүй.
- Олон улсын зах зээлээс хамааралтай.
- Боловсруулах үйлдвэр байхгүй.

Цаашид түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:

- Хууль эрх зүйн орчныг сайжруулах, тогтвортой болгох.
- Боловсруулах үйлдвэрүүдийг яаралтай барьж дуусгах.
- Дэд бүтэц олон улсын коридоруудыг нэмэгдүүлэх.
- Уул уурхайн ханган нийлүүлэлтэнд тохирсон ЖДҮ байгуулах шаардлагатай.

Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:

- Ажлын байр нэмэгдэнэ.
- Бүс нутгийн үсрэнгүй хөгжлийг бий болгоно

ЗҮҮН БҮС

Давуу тал буюу БОЛОМЖ

- Аялал жуулчлал-(Чингисийн тоонот нутаг, Алтан-овоо, Буйр нуур, Мэнэнгийн тал)
- Нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой-Барилга
- ХАА-н салбар
- МАА-(Хурдан морь)
- Газар тариалан
- Хадлан тэжээл, малын тэжээл
- Уул уурхай
- Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах.
- Олон Улсын онгоцны буудал байгуулах
- Казино байгуулах
- Морин тойруулга (Зүүн хойд Ази)



Сул тал буюу АСУУДАЛ

- Ажилгүйдэл
- Хүн ам сийрэг
- Хөрөнгө оруулалт, санхүүжилт дутмаг
- Дэд бүтэц
- Аймгаас боомт руу явсан хатуу хучилттай авто зам, төмөр зам байхгүй.
- Шилжих хөдөлгөөн их
- Шилжих хөдөлгөөн ихэссэнээс болж социализмын үед байсан сангийн аж ахуй, үйлдвэрийн газрууд зогссон.

Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 Ажилгүйдэл	<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэл хөгжөөгүй. - Чадварлаг боловсон хүчин хомс. 	<ul style="list-style-type: none"> - Хөрөнгө оруулалт татах - Байгалын нөөцийг ашиглаж, үйлдвэрүүдийг байгуулах. 	<ul style="list-style-type: none"> - Ажлын байраар хангагдана. - Шилжих хөдөлгөөн буурна.
2 Хөрөнгө санхүү, шинэ технологи хомс.	<ul style="list-style-type: none"> - Дэд бүтэц муу. - Гадаад харилцаа сул. - Хөрөнгө санхүүг татсан, шинэ технологийг нэвтрүүлэх талаар бодлого муу. 	<ul style="list-style-type: none"> - Гадаад харилцааг хөгжүүлэх замаар хөрөнгө оруулалт, шинэ технологийг татах. - ААНОАТ-ийг засаг захиргааны нэгжүүд өөрсдөө авах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Тулгараад буй бэрхшээлүүдийг шийднэ.
3 Дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> - Боомтууд засмал замгүй. - Төмөр зам хөгжөөгүй. 	<ul style="list-style-type: none"> - Гадны болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах. - Бонд босгох. - Концессын гэрээгээр дэд бүтцийг сайжруулах. 	<ul style="list-style-type: none"> - Далайд гарцтай болно. - Гадаад худалдаа идэвхижнэ.
4 Хүн ам зүйн асуудал (шилжих хөдөлгөөн).	<ul style="list-style-type: none"> - Ажлын байр хомс. - Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар муу. 	<ul style="list-style-type: none"> - Ажлын байрыг бий болгох. - Амьдрах орчныг сайжруулах. 	<ul style="list-style-type: none"> - Хотжилт бий болж, шилжих хөдөлгөөн буурна. - Боловсон хүчний нөөц бүрдэнэ.
5 Зах зээлийн багтаамж бага.	<ul style="list-style-type: none"> - Хүн ам цөөн, гадаад худалдаа муу. 	<ul style="list-style-type: none"> - Гадаад харилцааг хөгжүүлж, хүн амын суурьшлыг бий болгож, хүн амын өсөлтийг дэмжих. 	<ul style="list-style-type: none"> - Зах зээл өргөжиж, үйлдвэрлэл хөгжинэ.

Зүүн бүсийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:



- Уул уурхай
- Аялал жуулчлал
- ХАА, МАА
- Үйлдвэрлэл
- Худалдаа үйлчилгээ
- Зам барилга

Зүүн бүсийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур САЛБАР:

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Өнөөгийн нөхцөл байдал:

- Бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг байхгүй.
- Аялал жуулчлалын нэгдсэн маршрут байхгүй.
- Жуулчдыг амрах орчин нөхцөл муу, гадаад сурталчилгаа хийгддэггүй.
- Гадаад харилцаа сул.
- Аялал жуулчлалын салбарт ажиллах хүний нөөц хомс.

Цаашид түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:

- Аялал жуулчлалын бодлогын баримт бичиг боловсруулах.
- Гадаад, дотоод хөрөнгө оруулалт татах.
- Дэд бүтцийг хөгжүүлэх, хүний нөөцөө бэлдэх.
- Гадаадын жуулчдад нийлүүлэх бүтээгдэхүүн бий болгох.
- Чингис хааны цогцолбор байгуулах.
- Аймгийн төвүүдийг хот болгон хөгжүүлэх.
- Зочид буудал, ресторан, бэлэг дурсгалын үйлдвэрлэл, үйлчилгээг өндөр түвшинд хүргэх.
- Аялал жуулчлалын статистик судалгаатай болж мэдээллийн төвтэй болох.

Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:

- Эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгоно.
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Аялал жуулчлалын шинэ маршрут бий болно.
- Жуулчдыг татах цогцолборууд бий болно.
- Их Монгол улсын түүх соёлын төв бий болно.

ХАНГАЙН БҮС-1

Давуу тал буюу БОЛОМЖ

- Малын түүхий эдийн чанарын лабораторыг өргөтгөж, цогцоор хөгжүүлэх.
- Аялал жуулчлал, сувилал
- Бүс нутгийн нөөцөд тулгуурласан барилгын материалын үйлдвэрлэл
- Баруун аймгийг Улаанбаатар хоттой холбох ложистикийн төв байгуулах.



Сул тал буюу АСУУДАЛ

- Малын чанар муу
- Бэлчээрийн даацын асуудал
- ДЦС-ын тоног төхөөрөмжийн хуучирсан байдал (цахилгаан хүртээмж муу)
- Агаарын бохирдол
- Аялал жуулчлалын баазуудын төвлөрсөн байдал нь нэг нэгнийхээ үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 Малын түүхий эдийн чанар муу.	<ul style="list-style-type: none"> - Чанар харгалзахгүй түүхий эдийн урамшуулал олгодог. - Арьс ширний хувьд чанараас хамааран зах зээлийн үнэ адилхан. - Малын удам угшил муудсан. (эрлийзжүүлсэн) 	<ul style="list-style-type: none"> - Эрх зүйн орчин (лаборатори байгуулж, хяналтын тогтолцоог сайжруулах) - Малын түүхий эдийн урамшууллын зохицуулалтыг эргэж харах. - Тооллогыг чанартай явуулж бодит тоо гаргах. 	<ul style="list-style-type: none"> - Малын чанар сайжрах нь түүхий эдийн чанар сайжирч нэмүү өртөг бий болгох боломжтой. - Бэлчээрийн даац нэмэгдэнэ.
2 Бэлчээрийн даац муудсан.	<ul style="list-style-type: none"> - Бэлчээр зохион байгуулалтын ажил дутмаг. - Бог малын зохистой харьцаа алдагдсан. 	<ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн даацыг зөв зохистой ашиглах. - Малын удам угсааг сайжруулж үр шимийг нэмэгдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Малын чанар сайжирна - Байгаль экологийн тэнцвэрт байдал хадгалагдана.
3 ДЦС-ын тоног төхөөрөмжийн хуучирсан байдал.	<ul style="list-style-type: none"> - Хөрөнгө оруулалт шийдвэрлэгдэхгүй байна. 	<ul style="list-style-type: none"> - Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийг шинэчлэх. - Нүүрсний уурхай байгуулах. 	<ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний хүртээмж сайжирна. - ЖДҮ хөгжих боломж нэмэгдэнэ.
4 Агаарын бохирдол	<ul style="list-style-type: none"> - Нам даралтын зуухууд ихэссэн. - Гэр хорооллыг дэд бүтэцтэй холбоогүй. - Хог хаягдлыг шатааж байгаа нь. 	<ul style="list-style-type: none"> - ДЦС барьж яндангийн тоог цөөлөх. - Эрчих хүчний хэмнэлттэй зуух ашиглах. - Хог хаягдлын менежментийг сайжруулах. - Ногоон байгууламжын тоог нэмэгдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Агаарын бохирдлыг бууруулна. - Амьдралын таатай орчин бүрдэнэ.
5 Зах зээлийн багтаамж бага.	<ul style="list-style-type: none"> - Хүн ам цөөн, гадаад худалдаа муу. 	<ul style="list-style-type: none"> - Гадаад харилцааг хөгжүүлж, хүн амын суурьшлыг бий болгож, хүн амын өсөлтийг дэмжих. 	<ul style="list-style-type: none"> - Зах зээл өргөжиж, үйлдвэрлэл хөгжинө.

Хангайн бүс-1-ийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:



- Хөдөө аж ахуй
- Аялал жуулчлал
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэл
- Тээвэр, ложистик
- Уул уурхай

Хангайн бүс-1-ийн хөгжлийн тулгуур САЛБАР:

ХӨДӨӨ АЖ АХҮЙ

Өнөөгийн нөхцөл байдал:

- Малын тоогоор тэргүүлж байна.
- ДНБ-ийн 50-60 хувийг мал аж ахуйн салбар дангаараа бүрдүүлдэг.
- Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр ховор.
- Цагаан идээ боловсруулах ЖДҮ-ийг дэмжин бренд бүтээгдэхүүн бий болгоход анхааран ажиллаж байна.
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх атаршсан талбайн нөөцтэй.

Цаашид аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:

- Малын чанарыг сайжруулах.
- Мал сүргийг эрүүлжүүлэх, мал эмнэлэгийн үйлчилгээг сайжруулах.
- МAA-н бүтээгдэхүүнийг хагас болон бүрэн боловсруулах үйлдвэрүүд байгуулах.
- ХAA-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх тал дээр анхаарах.
- Өвлийн хүлэмжийн аж ахуйг олноор байгуулах.

Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:

- Тогтвортой ажлын байр нэмэгдэнэ.
- ДНБ нэмэгдэнэ.
- ХAA-н бүх төрлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр улсын хэрэгцээг хангана.
- Өрхийн орлого нэмэгдэж, ядуурал буурна.

ХАНГАЙН БҮС-2

Давуу тал буюу БОЛОМЖ

- Аж үйлдвэр технологийн парк.
- Боловсон хүчний нөөц боломж.
- Газар тариалан, МАА.
- Аялал жуулчлал
- Гадаад харилцаа, хөрөнгө оруулалт.



Сул тал буюу АСУУДАЛ

- Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн бодлого уялдаа холбоо сул.
- Эдийн засгийн бие даасан байдал хязгаарлагдмал.
- Аймгуудын уялдаа холбоо хөгжлийн бодлого байхгүй.
- ЖДҮ-ийн хөгжил.
- Хяналт үнэлгээ, иргэдийн оролцоо-Орон нутгийн байгууллага.

Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх ГАРЦ:

АСУУДАЛ	НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС	ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	ҮР ДҮН
1 Бүс нутгийн аймгууд хоорондын эдийн засгийн хөгжлийн бодлого уялдаа холбоо сул.	– Шийдвэр гаргагчдын тогтоол шийдвэрүүд бодит байдалтай уялдахгүй байна.	– Зөв оновчтой харилцааг зохицуулах хууль батлах.	– Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн бодлого оновчтой болно.
2 Бүсийн эдийн засгийн бие даасан байдал сул.	– Хууль, тогтоомж, гэрээ хэлцээр	– Төрийн зөв бодлого, бүс нутгийн, урт хугацааны хөгжлийн хөтөлбөр	– Бүсийн бие даасан байдал бий болно.
3 Аймгуудын уялдаа холбоо сул.	– Дов жалганы үзэл.	– Бүс нутгийн хэмжээнд хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхийн давуу талыг ард иргэдэд сурталчлах.	– Аймгуудын уялдаа сайжирч бодлогын болон үйл ажиллагааны давхардал буурна.
4 Аж үйлдвэрийн паркийг байгуулах ажил удаашралтай байгаа.	– Хүнд суртал – Бусад баримт (Хөрөнгө оруулалт)	– Төр засгийн тогтвортой байдал, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгох	– Хөгжил хурдасна
5 Бодлого, шийдвэрт тавих хяналт, үнэлгээ сул.	– Иргэдэд мэдээлэл хүргэх – Иргэд, орон нутгийн байгууллагын оролцоо сул	– Оролцоо, чадавхийг сайжруулах.	– Хөрөнгийн зарцуулалт үр ашигтай болно.

Хангайн бүс 2-ийн өрсөлдөх давуу талууд буюу хөгжлийн тулгуур САЛБАРУУД:



- Аялал жуулчлал
- Аж үйлдвэрийн парк-хүнд үйлдвэр, МАА гэх мэт.
- Олон улсын банк, санхүүгийн төв
- Эрчим хүч
- Эрүүл мэнд, боловсролын төв

Хангайн бүс 2-ийн өрсөлдөх давуу тал буюу хөгжлийн тулгуур САЛБАР:

АЖ ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИЙН ПАРК

Өнөөгийн нөхцөл байдал:

- Дэд бүтэц хөгжсөн
- Хүнд үйлдвэр хөгжсөн
- Хөвсгөл далай өв соёл ихтэй
- Боловсон хүчний чадавхитай

Цаашид түлхүү хөгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх алхамууд:

- Төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Барилгын материал үйлдвэрлэл байгуулах
- Мах, түүхий эд боловсруулах үйлдвэрлэл байгуулах (ноос, ноолуур, арьс шир).

Бүс нутгийн өрсөлдөх чадварт үзүүлэх эерэг нөлөө:

- Ажлын байр нэмэгдэнэ.
- Ажилтай, орлоготой байх зорилго хэрэгжинэ.

ХУРААНГУЙ

Чуулганы эхний өдөр оролцогчдод АӨЧТ-г бэлтгэдэг арга зүйн талаар танилцуулж оролцогчдын тайлангийн талаарх санал бодлыг сонсож цаашид хэрхэн сайжруулах талаар хэлэлцсэн. Мөн эхний өдрийн илтгэлүүд нь өрсөлдөх чадвар гэж юу болох түүнийг хэрхэн ашиглах талаар оролцогчдод ойлголт өгч санал бодлыг нь сонсож, бүс нутгийн өрсөлдөөний давуу болон сул талыг тодорхойлсон юм.

Харин хоёр дахь өдрийн илтгэлүүд нь орон нутгийн бизнесийн орчин болон хөдөө орон нутгийн хөгжлийн асуудлыг хэлэлцэж, АӨЧТ-д ашигладаг статистик мэдээллийг хэрхэн боловсруулж, бэлтгэдэг талаар танилцуулсан. Мөн бүс нутгийн хэмжээнд хөгжүүлж болох эдийн засгийн тулгуур салбарыг тодорхойлж, тухайн салбарыг хөгжүүлэхэд тулгараад буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон.

Чуулганд оролцогчид АӨЧТ-г удирдлагын түвшинд ашиглахад тохиромжтой судалгаа болохыг онцлоод “Аймгуудын өрсөлдөх чадварын чуулган”-ыг цаашид жил бүр тогтмол зохион байгуулж байхаар тохиролцов.



АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТУХАЙ

Судалгааны зорилго нь аймгуудын өрсөлдөх чадварыг үнэлж хөгжлийн ялгаа хэр их байна, давуу болон сул тал нь юу вэ гэдгийг гаргаж ирэхэд чиглэсэн. Аймаг орон нутаг энэ судалгааны үр дүнгээр бусад аймагтай өрсөлдөхдөө гол нь биш өөрийн давуу болон сул талыг тодорхойлж түүнийгээ тордох талаар анхаарахад илүү ашиглах хэрэгтэй.

Аймгуудын өрсөлдөх чадварыг хэмжих үзүүлэлтүүд

Энэхүү судалгааны хүрээнд аймгуудын өрсөлдөх чадварыг үнэлэн эрэмбэлэхдээ эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц гэсэн үндсэн 4 бүлэг, тэдгээрийг нарийвчлан үнэлэх тус бүр 4 дэд бүлэг буюу нийт 16 дэд бүлгийн хүрээнд аймгуудын өрсөлдөх чадварыг олон талаас нь тодотгон харуулах 180 шалгуур үзүүлэлт ашигласан. Энэ нь өрсөлдөх чадварыг тал бүрээс нь илүү тодорхой үнэлэх боломжийг олгосон.

Өрсөлдөх чадварын индекс тооцох, эрэмбэлэхдээ үзүүлэлт бүрийн стандартчилсан үнэлгээг тооцож бүлэг тус бүрийн дундаж стандартчилсан үнэлгээг гаргана. Улмаар 4 бүлгийн индекс болон нэгдсэн индексийн дүнгээр аймгуудыг эрэмбэлэх ба индексийн утга хамгийн өндөр аймгийг 100 гэж тооцон аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээг оноогоор илэрхийлж, утгын дарааллаар аймгуудыг эрэмбэлэнэ.


Ерөнхий үнэлгээний эрэмбэ нь тухайн аймгийн өрсөлдөх чадварын байр суурь бусад аймагтай харьцуулахад ямар байгааг харуулдаг. Өөрөөр хэлбэл өрсөлдөх чадвараар хамгийн дээгүүр эрэмбэлэгдсэн аймгийн хувьд тухайн аймаг өрсөлдөх чадвартай гэж тодорхойлохоос илүү тухайн аймаг бусад аймагтай харьцуулахад өрсөлдөх чадвар сайтай гэж ойлгох нь зүйтэй юм.

Мэдээллийн эх үүсвэр


Аймгуудын өрсөлдөх чадварын судалгаа нь өрсөлдөх чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийг албан ёсны статистик мэдээлэл болон санал асуулгын мэдээллээр бүрдүүлдэг. Аймгуудын өрсөлдөх чадварыг үнэлэх нийт 180 шалгуур үзүүлэлтийн ойролцоогоор 2/3 нь буюу 116 нь статистик мэдээлэл, 1/3 нь буюу 64 нь санал асуулгын мэдээлэл байна. Статистик мэдээллийн 25 хувь буюу 30 нь ерөнхий мэдээлэл байх ба өрсөлдөх чадварын индексийн тооцооллод ордоггүй, нэмэлт мэдээлэл өгөх зорилготой үзүүлэлтүүд юм.

Удирдах ажилтны санал асуулгад хувийн хэвшлийн төлөөлөл буюу аймагт үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагын дунд болон дээд шатны удирдах ажилтнууд хамрагддаг ба тухайн аймаг дахь бизнес эрхлэх таатай орчин, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн талаарх тэдний ойлголт, тухайн орчин дахь нөхцөл байдлыг бодитоор хэрхэн үнэлж буйг судалдаг.

Аймгуудын өрсөлдөх чадварын хүчин зүйлс:



Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ:



Орон нутгийн өрсөлдөх чадварыг хойш татаж буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэхийн тулд:

1. Орон нутгийн хөгжлийн бодлого, зорилтуудыг оновчтой тодорхойлох

Аймаг бүр өөрийн гэсэн хөгжлийн бодлоготой байдаг ч илүү урт хугацааны, тухайн аймгийн онцлогт тохирсон, өрсөлдөх чадварын давууталд тулгуурласан хөгжлийн бодлого үгүйлэгдэж байна. Ялангуяа орон нутагт төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж буй энэ цаг үед төсвийг хэрхэн үр ашигтай зарцуулах, орон нутгийн хөгжлийг хангах оновчтой бодлого хэрэгжүүлэх нь чухал.

2. Дэд бүтцийг хөгжүүлэх

Аймгийн хөгжил сул байгаа нь юун түрүүн тэнд амьдарч буй ард иргэдийн амьдрах таатай орчин бүрэлдсэн эсэх, амьдарч буй газар нутгаас үл хамааран эрүүл мэнд, боловсролын болон нийгмийн бусад үйлчилгээг чанартайгаар хүртэж

чадаж буй эсэхээр хэмжигдэнэ. Одоогийн байдлаар аймаг бүрт ийм нөхцөл хараахан бүрдэж амжаагүй байна. Гэхдээ тодорхой хэмжээний ахиц дэвшил гарч, дэд бүтцийн үзүүлэлтийн өрсөлдөх чадварын ононд ихээхэн өөрчлөлт гарчээ.

3. Бизнесийн орчныг сайжруулах

Монгол Улсад 45 мянган хувийн хэвшлийн аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулдагас 70 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 15 мянга орчим аж ахуйн нэгж буюу жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлөөлөл тэдэнд тулгардаг хамгийн том асуудлыг бизнесээ өргөжүүлэн тэлэх хөрөнгө оруулалт, санхүүжилт олох боломж хязгаарлагдмал байдаг хэмээн тодорхойлж байна.

Өрсөлдөх чадварын хүчин зүйлсийн үнэлгээ

ЭДИЙН ЗАСГИЙН ТАМИР ТЭНХЭЭ

- Эдийн засаг
- Эдийн засгийн салбарууд
- Хүн амын амьжиргааны түвшин
- Хөдөлмөр эрхлэлт



ЗАСАГЛАЛЫН ҮР АШИГ

- Аймгийн төсөв
- Институцийн тогтолцоо
- Бизнесийн эрх зүй
- Нийгмийн тогтолцоо



Өрсөлдөх чадварын хүчин зүйлсийн үнэлгээ

БИЗНЕСИЙН ҮР АШИГ

- Бизнесийн орчин
- Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж
- Санхүү
- Менежментийн хэвшил



ДЭД БҮТЭЦ

- Үндсэн дэд бүтэц
- Технологийн дэд бүтэц
- Шинжлэх ухаан, боловсрол, соёл
- Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин




Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ


ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ХАРЬЦУУЛАЛТ

- Тухайн аймгийн оноо
- Аймгуудын дундаж оноо


Архангай




Баян-Өлгий




Баянхонгор




Булган



Говь-Алтай



Говьсүмбэр




Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ


ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ХАРЬЦУУЛАЛТ

- Тухайн аймгийн оноо
- Аймгуудын дундаж оноо


Дархан-Уул




Дорноговь




Дорнод




Дундговь



Завхан



Орхон




Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ


ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ХАРЬЦУУЛАЛТ

— Тухайн аймгийн оноо
 — Аймгуудын дундаж оноо


Өвөрхангай




Өмнөговь




Сүхбаатар




Сэлэнгэ



Төв



Увс




Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ


ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ХАРЬЦУУЛАЛТ

- Тухайн аймгийн оноо
- Аймгуудын дундаж оноо


Ховд



Хөвсгөл



Хэнтий



АӨЧТ-гийн ИНФОГРАФИК

МОНГОЛ УЛС: АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН 2013 Аймагуудын хамгийн хамгийн үзүүлэлтүүд

